



## **Хэрэгцээ шаардлагаар баталгаажсан орлогын доод хэмжээний мэдээллийн хуудас**

Хэрэгцээ шаардлагаар баталгаажсан орлогын доод хэмжээ (BMS) гэдэг нь санхүүгийн хүндрэл бэрхшээлтэй тулгарч, өөрийн боломж бололцоогоороо (орлого, өөр бусад хөрөнгөөр) амьжиргаагаа залгуулах боломжгүй болсон хүмүүсийн ахуй, амьжиргааны хэрэгцээг хангах зорилготой тэтгэмж юм.

### **Тэтгэмж авахад тавигдах шаардлага**

- Орлого огт байхгүй эсвэл маш бага орлого олдог байх
- Ямар ч хөрөнгөгүй байх
- Доод Австрид байнга оршин суудаг байх
- Австри улсад байнга оршин суух эрхтэй байх
- Ажил хийх чадвартай бол цаашид ажил хөдөлмөр эрхлэх хүсэл эрмэлзэлтэй байх
- Нийгэмд дасан зохицох хүсэл эрмэлзэлтэй байх (жишээлбэл герман хэлний сургалт, үнэ цэнэ, чиг баримжаа олгох сургалтад хамрагдах)
- Холбогдох баримтуудыг гаргаж өгөх (Хавсралт 1-ийг үзнэ үү)

### **Өргөдөл хүлээн авах газар**

- Дүүргийн засаг захиргаа эсвэл хотын даргын алба
- Оршин суугаа газрын эрх бүхий байгууллага

### **Шийдвэр гаргах байгууллага**

- Дүүргийн засаг захиргаа эсвэл хотын даргын алба

### **Тэтгэмж**

- Шаардлагын хамгийн доод хэмжээгээр тооцоолсон мөнгөн тэтгэмж эсвэл төлбөр олгох (2-р хавсралтыг үзнэ үү)
- Сүүлийн зургаан жилд таваас доош жилийн хугацаанд Австрид байнга оршин сууж байгаа хүмүүс нийгэмд дасан зохицохтой холбоотой наад захын хэм хэмжээг дагаж мөрдөнө. (3-р хавсралтыг үзнэ үү).

- Нэг орон сууц эсвэл дундын байранд амьдардаг бүх хүмүүст олгогдох тэтгэмжийн нийт хэмжээ 1,500 еврогоор хязгаарлагдана.
- Хуулиар тогтоосон эрүүл мэндийн даатгалын төлбөр
- Ажиллах хүчинд дахин нэгдэж буй хүмүүст олгох урамшуулал

### **Эрүүл мэндийн даатгалын төлбөр / хамрагдах хүсэлт**

- Төлбөрийг үндэсний харилцах дансанд хийнэ (бүх хүмүүст хамаарна)
- Тэтгэмжийг сарын сүүлээр шилжүүлнэ
- Эрх бүхий байгууллага нь зөвхөн өргөдөл гаргагчийг Доод Австрийн Нийгмийн даатгалд шууд хамруулахаар бүртгэнэ.  
 → Өргөдөл гаргагчийн хамаарах хүмүүсийн тухайд бол хамтын даатгалд хамрагдах өргөдлийг Доод Австрийн Нийгмийн даатгалын газарт гаргах ёстой (гарах төлбөр нь хэрэгцээ шаардлагаар баталгаажсан орлогын доод хэмжээний тэтгэмжийн хүрээнд мөн адил төлөгдөнө).

### **Үүрэг хариуцлага**

- Шаардлага хангасан байдалд аливаа өөрчлөлт орвол энэ тухайгаа дүүргийн засаг захиргаа эсвэл хотын даргын албанд хоёр долоо хоногийн дотор мэдэгдэх ёстой.

Жишээлбэл:

- Орлого эсвэл өмч хөрөнгө зэрэгт өөрчлөлт орох
- Амьдрах нөхцөл эсвэл гэр бүлийн харьцаанд өөрчлөлт орох
- Австрид хууль ёсны дагуу байнга оршин суух байдалд өөрчлөлт орох
- Орлого сайтай ажилд орох
- Эмнэлэг эсвэл эмчилгээний ямар нэгэн байгууллагад хэвтэж эмчлүүлэх
- Хоёр долоо хоногоос илүү хугацаагаар гадагш явах
- Гуравдагч талаас гаргасан нэхэмжлэлийн талаар мэдэгдэх (жишээлбэл материаллаг тусламж, өвчний улмаас олгох тэтгэмж )
- Ажиллах амлалт
- Герман хэл сайн мэддэггүй бол герман хэлний сургалтанд хамрагдах, мөн ажлын зах зээлд өрсөлдөх чадамж, ажиллах чадвар, нийгэмшиж тогтворжих

байдлаа ямар нэг аргаар сайжруулах (жишээлбэл олон нийтийн сайн дурын ажил хийх).

- Австри улсад сүүлийн 6 жилд 5 жилээс бага хугацаанд оршин сууж буй хүмүүс дор хаяж 8 цагийн үнэ цэнэ, чиг баримжаа олгох сургалтанд хамрагдах.
- Австри улсад сүүлийн 6 жилд 5 жилээс бага хугацаанд оршин сууж буй хүмүүс герман хэл сурч, хэлний мэдлэгээ А2 түвшинд хүртэл сайжруулах.
- Австри улсад сүүлийн 6 жилд 5 жилээс бага хугацаанд оршин сууж буй хүмүүс Нийгэмд дасан зохицох гэрээ байгуулж, хэрэгжүүлэх.

### **Татгалзах / багасгах / цуцлах**

Ажил хөдөлмөр эрхлэхээс татгалзах, нийгэмд дасан зохицох арга хэмжээ (герман хэлний сургалт, үнэ цэнэ, чиг баримжаа олгох сургалт, бусад олон нийтийн ажилд), Олон нийтийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний сургалтад хамрагдахгүй байх, ямар нэг хүндэтгэх шалтгаангүйгээр таслах тохиолдолд хэрэгцээ шаардлагаар баталгаажсан орлогын доод хэмжээний тэтгэмжийн хүсэлтэд татгалзсан хариу өгөх болно. Одоо авч байгаа тэтгэмжийн хэмжээг бууруулж эсвэл цуцлах болно.

### **Буцаалт, нөхөн олговор, торгууль**

Дараах тохиолдолд олгогдсон тэтгэмжийг буцаан төлүүлж, торгууль ногдуулна.

Үүнд:

- Засаг захиргааны байгууллагад орсон өөрчлөлтүүдийн талаар мэдээлэх үүргээ зөрчих
- Худал мэдээлэл өгөх эсвэл холбогдох мэдээллийг гаргаж өгөхгүй байх
- Ашиглаж болох өмч хөрөнгөтэй болох (жишээлбэл, өв шилжүүлж авах)
- Тэтгэмж авагч нөхөн төлбөр хийх

### **Ажлын зах зээлд хөл тавьж, цалин сайтай ажилд орсны урамшуулал**

Ажлын зах зээлд нэгдэж орсны урамшуулал нь хэрэгцээ шаардлагаар баталгаажсан орлогын доод хэмжээний тэтгэмжийг хамгийн багадаа сүүлийн 6 сарын турш тасралтгүй авч, улмаар ажилд орсон хүмүүст хамаарна (хэдийгээр бага ч гэсэн).

Өргөдөл ба түүнийг илгээх эцсийн хугацаа:

Өргөдөл гаргахад доорх хоёр алхмыг гүйцэтгэх шаардлагатай:

1. Цалинтай ажилд орсон тохиолдолд тус ажлаа хийж эхэлсэн огноог дүүргийн засаг захиргаа эсвэл хотын даргын албанд хоёр долоо хоногийн дотор мэдэгдэх.
2. Цалинтай ажилд орсноос хойш хамгийн ихдээ гэхэд 4 долоо хоногийн дотор ажлын зах зээлд давтан орсны урамшуулал авах хүсэлтээ аман эсвэл бичгэн хэлбэрээр дүүргийн засаг захиргаа эсвэл хотын даргын албанд ирүүлэх шаардлагатай. Мөн түүнчлэн цалинтай ажилд орж байгаагаа мэдэгдэх үедээ урамшуулал авах хүсэлтээ гаргаж болно.

Урамшууллын хэмжээ:

Ажлын зах зээлд давтан орсны урамшууллын хэмжээ нь цэвэр орлогын гуравны нэгтэй тэнцэнэ (дээд хэмжээ). Хэрэв цэвэр орлого болон урамшуулал нь ганц бие хүний орлогын доод хэмжээнээс 140%-иар (€1182.24; 2017) илүү гарвал ажлын зах зээлд давтан орсны урамшууллын хэмжээ тэр хэрээр буурах болно.

Урамшууллыг хамгийн ихдээ 12 сарын турш олгодог. Түр хугацааны ажил хийх бол урамшууллыг хөдөлмөр эрхэлсэн хугацааны дагуу олгох болно.

## **Хавсралт 1:**

### **Бүрдүүлэх баримт бичиг:**

#### **1. Хувийн мэдээлэл:**

- o Албан ёсны биеийн байцаалт
- o Төрсний гэрчилгээ
- o Иргэншлийн баталгаа
- o ЕЭЗБ-ын орнуудын иргэдийн хувьд гадаад цагдаагийн байгууллагын бүртгэлийн гэрчилгээ
- o ЕЭЗБ-ын бус орнуудын иргэдийн хувьд байнгын оршин суух зөвшөөрөл, орогнол хүссэн мэдэгдэл
- o Итгэмжлэл (асран хамгаалах шийдвэр, итгэмжлэлт бичиг гэх мэт.)
- o Гэр бүл цуцлалтын тогтоол, маргааныг таслан шийдвэрлэсэн шийдвэрийн хуулбар (тус бүрийг нотариатаар баталгаажуулсан байх)

#### **2. Орлого, хөрөнгийн дэлгэрэнгүй мэдээлэл:**

##### 2.1. Орлого, асаргааны тэтгэмжийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл:

- o Цалингийн гэрчилгээ, орлогын баталгаа (сүүлийн 3 сарын) (бага цалинтай ажил эрхлэлт үүнд багтана)
- o Олон нийтийн хөдөлмөр эрхлэлт, үйлчилгээний газраас өгсөн бичгэн хэлбэрийн баталгаа
- o PVA (тэтгэврийн даатгал), SVA (нийгмийн даатгал), ÖBB (Австрийн төмөр зам), VAEB (Австрийн төмөр замын даатгалын байгууллага), BVA (олон нийтийн үйлчилгээний Даатгалын корпораци), гадаад даатгал зэргээс авсан бичгэн хэлбэрийн баталгаа
- o Өвчний улмаас олгох тэтгэмжийн баталгаа
- o Жирэмсэний тэтгэмж / (нэмэгдэл) хүүхэд харах тэтгэмжийн баталгаа
- o Тэтгэврийн нэмэлт төлбөрийн баталгаа
- o Аваар ослын тэтгэмжийн баталгаа
- o Материаллаг / хоол хүнсний тусламж хүссэн нэхэмжлэлийг нотлох баримт
- o Түрээс ба/эсвэл орон сууцны зээлийн гэрээ
- o Орлого баталгаажуулах бусад баримт (насан туршид авах тэтгэмжийн орлого гэх мэт)
- o Асаргааны тэтгэмжийн мэдэгдэл
- o Сүүлийн 3 сарын орлого, зардлын дэлгэрэнгүй тайлан

## 2.2. Хөрөнгийн тухай мэдээлэл

- o Банкны тайлан (хүсэлт гаргасан огнооноос өмнөх гурван сарын хугацааг хамарна)
- o Даатгалын гэрээ (оршуулгын даатгалын гэрээ, амьдралын даатгал гэх мэт)
- o Хадгаламжийн дэвтрүүд
- o Барилгын зээлийн гэрээ
- o Хувьцаа, бонд
- o Сан
- o Автомашин (суудлын, ачааны, трактор гэх мэт)
- o Бусад хөрөнгө (мөнгөн хөрөнгө гэх мэт)
- o Газар бүртгэлийн гэрчилгээ

## ЧУХАЛ ТЭМДЭГЛЭЛ:

Дэмжлэг хайж байгаа хүний хувьд боломжгүй гэдэг нь илт харагдаж байхаас бусад тохиолдолд гуравдагч талд (эцэг эх, хань ижил гэх мэт) хандан санхүүгийн туслалцаа хүсэх хууль ёсны оролдлого хийх үүрэгтэй. Гуравдагч тал ийнхүү төлбөр төлөх шаардлагыг биелүүлвэл хэрэгцээ шаардлагаар баталгаажсан орлогын доод хэмжээний тэтгэмжийг төлөх, эсвэл ердийн хэмжээнд төлөх шаардлагагүй болно.

## **3. Доор дурдсан бичиг баримтыг мөн адил бүрдүүлэх шаардлагатай:**

### 3.1. Нэмэлт нотлох баримт:

- o Ажил хайгчаар бүртгэгдсэн бүртгэлийн баталгаа
- o Австри улсын Хөдөлмөрийн зах зээлийн зөвлөлийн хяналтын гэрээ
- o Австри улсын Хөдөлмөрийн зах зээлийн зөвлөлийн татгалзах мэдэгдэл
- o Тэтгэвэр хүссэн өргөдөл
- o Материаллаг тусламж хүссэн өргөдөл
- o Эмчийн магадлагаа, ажиллах чадварын үнэлгээ
- o Нийгэмшиж, тогтворжих талаар авсан арга хэмжээний нотолгоо (герман хэлний сургалт гэх мэт)
- o Хичээлд явсныг батлах бичгэн баталгаа

### 3.2. Орон сууц түрээслэх үнэ өртөг

- o Түрээсийн гэрээ / хамтын холбооны гэрээ
- o Одоогийн түрээс, урсгал зардлын хангамж
- o Одоогийн түрээсийн төлбөрийн баталгаа
- o Орон сууцны тэтгэмжийн мэдээлэл

3.3. Хувийн эзэмшлийн орон сууцны урсгал зардлыг нотлох баримт:

- o Байрны даатгал (гэрээ)
- o Яндан цэвэрлүүлэх төлбөр
- o Хогны төлбөр
- o Хэрэглээний зардал (ус/бохир)

## Хавсралт 2:

### 2017 оны доод хэм хэмжээ:

<b>Хэрэгцээ шаардлагаар баталгаажсан орлогын доод хэмжээний тэтгэмж</b>			
<b>Доод хэм хэмжээ – Түрээс - 2017</b>			
<b>Хүмүүсийн ангилал</b>	<b>Амьжиргааны зардал</b>	<b>Байранд олгох дэмжлэг</b>	<b>Нийт</b>
Ганц бие хүн/ганц бие эцэг/эх 100%	€633.35	€211.11	€844.46
Хос/хамтран амьдрагч хос нэг байранд 150%	€950.02	€316.68	€1266.70
Насанд хүрсэн хүн нийтийн байранд 75%	€ 475.01	€158.34	€633.35
Нийтийн байранд амьдардаг гуравдах том эсвэл бага хүүхэд, гэр бүлийн өөр гишүүнээс материаллаг тусламж авах эрхтэй хүн, 50%	€316.67	€105.56	€422.23
Гэр бүлийн тэтгэмж авах эрхтэй насанд хүрээгүй хүн, 23%	€145.67	€48.56	€194.23

<b>Хэрэгцээ шаардлагаар баталгаажсан орлогын доод хэмжээний тэтгэмж</b>			
<b>Доод хэм хэмжээ – Өмч хөрөнгө - 2017</b>			
<b>Хүмүүсийн ангилал</b>	<b>Амьдралын зардал</b>	<b>Байрны дэмжлэг</b>	<b>Нийт</b>
Ганц бие хүн/ганц бие эцэг/эх 100%	€633.35	€105.56	€738.91
Хос/хамтран амьдрагч хос нэг байранд 150%	€950.02	€158.34	€1108.36
Насанд хүрсэн хүн нийтийн байранд 75%	€475.01	€79.17	€554.18
Нийтийн байранд амьдардаг гуравдах том эсвэл бага хүүхэд, гэр бүлийн өөр гишүүнээс материаллаг тусламж авах эрхтэй хүн, 50%	€316.67	€52.78	€369.45
Гэр бүлийн тэтгэмж авах эрхтэй насанд хүрээгүй хүн, 23%	€145.67	€24.28	€169.95

Орон сууцны байгууллагаас дэмжлэг хүсч буй хүмүүсийн хувийн хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэгдсэн хэрэгцээ шаардлагаар баталгаажсан орлогын доод хэмжээний тэтгэмжийн суурь хэмжээ (x 13)	€67.87
---	--------

Нэг орон сууц эсвэл нийтийн байранд хамт амьдарч байгаа бүх хүний доод хэм хэмжээг хангах нийт дүн нь **€1500-оор хязгаарлагдана.**

**Үүнд дараах хамаарахгүй:** Асаргааны тэтгэмж авч байгаа эсвэл гэр бүлийн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлсэн эсвэл ажиллах чадвар алдсан хүмүүст хамаарах доод хэм хэмжээг бууруулахгүй.



### Хавсралт 3:

#### Доод хэм хэмжээ – Дасан зохицол:

Доод хэм хэмжээ – Дасан зохицол			
Хүмүүсийн ангилал	Амьжиргааны зардал	Байрны дэмжлэг	Нийт
Ганц бие эцэг эхчүүд, хүн тус бүрт	€522.50	€300.00	€822.50
Ганцаараа эсвэл насанд хүрсэн өөр хүнтэй нэг гэрт эсвэл нийтийн байранд хамт амьдардаг насанд хүрсэн хүмүүс, хүн тус бүрт	€422.50	€150.00	€572.50
Нийтийн байранд амьдардаг гурав дахь эсвэл бусад хүмүүс, хүн тус бүрт	€422.50	-	€422.50
Доод хэм хэмжээ – Дасан зохицлын тэтгэмж авч байгаа ганц бие эцэг эхтэй хамт амьдарч байгаа насанд хүрээгүй эхний гурван хүүхэд, хүн тус бүрт	€179.17	-	€179.17
Насанд хүрээгүй хүмүүс, хүн тус бүрт	€129.17	-	€129.17

Нэг орон сууц эсвэл нийтийн байранд хамт амьдарч байгаа бүх хүний доод хэм хэмжээг хангах нийт дүн нь **€1500-оор хязгаарлагдана.**

**Үүнд дараах хамаарахгүй:** Асаргааны тэтгэмж авч байгаа эсвэл гэр бүлийн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлсэн эсвэл ажиллах чадвар алдсан хүмүүст хамаарах доод хэм хэмжээг бууруулахгүй.